

## БНСУ-ЫН ОЛОН НИЙТИЙН ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА

Д.Оюунцэцэг\*

**Abstract:** *The new order created in international politics after the end of the Cold War has provided countries with the opportunity to participate independently and actively in international relations. Due to enhance country's prestige and image on the international stage, all actors of international politics actively pursue soft power policies depended on its own resources. For Korea, has become to pay high attention and focus on the middle power policies based on soft power, such as cultural and public diplomacy. In this article, we focus on the changes and specific characters of public diplomacy of the Republic of Korea.*

**Key words:** *The Republic of Korea, Public diplomacy, Public Diplomacy Act of the Republic of Korea, soft power theory.*

\*\*\*

### 1. Олон нийтийн дипломат бодлого ажиллагааны талаарх ойлголт

Олон нийтийн дипломат ажиллагаа нь өөрийн явуулж буй бодлого, үйл ажиллагаагаараа дамжуулан гадаад дотоод орчинд харилцан ойлголцох, санал нэгдэх, дэмжлэг авах, ятгах гэх мэт харилцагч талын сэтгэлийг татах зорилготой гэдэг утгаараа зөөлөн хүчний мөн чанартай агуулга нийцэх агаад зөөлөн нөөцийн үндсэн элементүүдийн дотроос практикт өргөн ашиглагддаг нөөц бол олон нийтийн дипломат ажиллагаа юм. Ян Меллисен (2005) “Олон нийтийн дипломат ажиллагаа нь өөрийн улсын зорилго, явуулж буй бодлого төдийгүй үзэл баримтлал, тогтолцоо, соёлын талаарх ойлголтыг дээшлүүлэхийн тулд Засгийн газраас гадаад улсын олон нийттэй харилцан ойлголцох үйл явц юм” хэмээн томъёолсон байдаг.

Олон нийтийн дипломат ажиллагааны үндсэн зорилго нь хэл, соёл, хөгжлийн тусламж, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа гэх мэт олон төрлийн зөөлөн нөөцийг ашиглан гадаад улсын олон нийтэд шууд хандан өөрийн улсын түүх, уламжлал, соёл, урлаг, үнэт зүйл, бодлого, хэтийн төлөв зэргийн талаарх тэдний ойлголтыг өргөжүүлж, итгэлийг нь олж авснаар өөрийн орны талаар эерэг имиж, дүр зургийг төрүүлэх, өсгөх, цаашлаад гадаад харилцаагаа хөгжүүлэх, улсын брэнд үнэ цэнийг өсгөж, олон улсын нийгэм дэхь өөрийн улсын нөлөөг дээшлүүлэхэд оршдог. Олон нийтийн дипломат ажиллагаанд соёл, спорт, хэвлэл мэдээлэлийн дипломат ажиллагаа зэрэг багтана. Олон нийтийн дипломат ажиллагаанд оролцогчид нь засгийн газар, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, сургууль боловсролын байгууллага, иргэд нийгмийн байгууллага, мөн бизнесийн байгууллага, хувь хүн

<sup>1</sup> МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Ази Судлалын Тэнхимийн багш, БНСУ-ын Сөүл Үндэсний Их Сургуулийн Нийгмийн Ухааны Сургуулийн Улс төр, олон улсын харилцааны тэнхимийн докторант.

иргэд байдаг. Олон нийтийн дипломат ажиллагааны үр дүн дунд, урт хугацааны байдаг (Melissen, Jan, 2005).

Олон нийтийн дипломат ажиллагааны түүхээс сөхөж үзвэл энэхүү нэр томъёо нь анх 1965 онд АНУ-ын дипломатч байсан Тафтсын их сургуулийн Флечер сургуулийн захирал Эдмонд Голлион “Эдвард Морроу Олон нийтийн дипломат ажиллагааны төв”-ийг байгуулснаар хэрэглэгдэж эхэлсэн гэдэг. Тухайн үеийн олон нийтийн дипломат ажиллагаа нь хүйтэн дайны системийн дор хатуу хүчийг ашиглах явцад харилцагч улсын бодлогод нөлөөлөхийн тулд тухайн улсын олон нийтийн үзэл бодлыг өөрчлөхөд чиглэсэн бодлого байсан юм. XX зууны олон нийтийн дипломат ажиллагаа нь дэлхийн II дайнаас үүдэлтэй гарч ирж, хүйтэн дайны үед ухуулга голлосон явагдаж байсан бол 1990-ээд оны үеэс, хүйтэн дайн дууссанаар олон нийтийн дипломат ажиллагааны талаар салбарын хэмжээнд авч үзэх нь тодорхой хугацаагаар багассан юм. Гэвч 9.11-ний террорист халдлагаас хойш олон улсын харилцаанд зөөлөн хүч чухал гэдэг нь тодорхой болж ирснээр, даяаршил хурдацтайгаар тархаж, ардчилал өрнөх болсноор улс бус тоглогчид дипломат ажиллагаанд оролцох болсноор, мөн сошиал медиа, сошиал нетворк гэх мэт харилцаа холбооны салбарын үсрэнгүй хөгжлийн үр дүнд цаг хугацаа орон зайн ялгаа устан, мэдээллийн чөлөөт байдал хангагдах болсон зэргээс үүдэн олон нийтэд тулгуурласан, олон нийтэд чиглэсэн дипломат ажиллагаа чухалчлагдах болж, дипломат арга ажиллагааны загварууд өөрчлөгдөн хувьсах явцад олон нийтийн дипломат ажиллагаа дахин гарч ирсэн юм.

Хүснэгт 1. Дипломат ажиллагааны хэлбэрүүд ба үндсэн үзүүлэлтүүд.

Дипломат ажиллагааны элементүүд	Уламжлалт дипломат ажиллагаа	XX зууны олон нийтийн дипломат ажиллагаа	XXI зууны шинэ олон нийтийн дипломат ажиллагаа
Тоглогч	Засгийн Газар	Засгийн газар	Засгийн газар болон бусад улс бус тоглогчид
Харилцагч	Харилцагч улсын Засгийн Газар	Харилцагч улсын Засгийн Газар болон олон нийт (өөрийн улсын ард иргэд орохгүй)	Харилцагч улсын Засгийн Газар болон олон нийт (өөрийн улсын ард иргэд орно)
Үйлчлэх хүч	Хатуу хүч	Хатуу хүч > Зөөлөн хүч	Хатуу хүч < Зөөлөн хүч
Дамжуулах арга хэрэгсэл	Засгийн Газар хоорондын албан ёсны яриа хэлэлцээр	Ухуулга сурталчилгаа, PR компани ажиллагаа, хэвлэл мэдээлэл	Интернэт, сошиал нетворк гэх мэт олон төрлийн дижитал дамжуулах суваг
Харилцааны хэлбэр	Хэвтээ (Засгийн Газар хоорондын)	Босоо, нэг тал руу чиглэсэн, тэгш хэмгүй	Хэвтээ, хоёр тал руу чиглэсэн, тэгш хэмт
Харилцааны хэв маяг	Хаалттай хэлэлцээр	Хаалттай харилцаа	Нээлттэй харилцаа

*Эх сурвалж: БНСУ-ын Гадаад хэргийн яам, Олон нийтийн дипломат ажиллагаа цахим хуудас <sup>2</sup>*

<sup>2</sup> Cit.20/03/2018. Retrieved from. <http://www.publicdiplomacy.go.kr/introduce/public.jsp>

Олон нийтийн дипломат ажиллагааны гол агуулга мэдээлэл дамжуулах гэдэг утгаараа мэдээлэл технологийн хөгжлийг ашигласаар ирсэн. Тэр тусмаа ХХI зууны олон нийтийн дипломат ажиллагаа нь медиа суваг, интернэтийн технологийг ашиглан мэдээлэл дамжуулан солилцохоос гадна мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, дамжуулах үүрэг гүйцэтгэх болсноороо онцлогтой. Харилцагч улс болон өөрийн орны иргэдийн оюун санаа, үзэл бодол, эрхэмлэх үнэт зүйлд чиглэсэн дипломат үйл ажиллагаа гэдэг утгаараа олон нийтийн дипломат ажиллагаагаар дамжин хүрч байгаа соёл, мэдлэг, мэдээлэл нь зөөлөн хүчний үндсэн эх сурвалж болох юм. Шинэ зууны олон нийтийн дипломат ажиллагаа нь илүү олон тоглогчид, илүү өргөн хүрээг хамарсан, нетворк түвшинд явагдах болсныг илтгэж байгаа юм.

Олон нийтийн дипломат ажиллагааны нөөц нь ардчилал, үзэл баримтлал, үнэт зүйл, эдийн засгийн өндөр хөгжил, технологийн дэвшилтэт байдал, соёл урлаг, соёлын үйлдвэрлэлийн тэргүүлэх чанар гэх зэрэг давуу талууд байхаас гадна уламжлал, орчин үе, үндэстний өвөр төрх(identity) зэрэг өвөрмөц онцлогууд ч багтаж болно. Жишээлбэл, судлаач И Гын БНСУ-ын хувьд олон нийтийн дипломат ажиллагааны нөөцөд эдийн засгийн эрс өсөлт, нэн шинэ технологийн хөгжил болон ардчилалд нэгэн зэрэг хүрч чадсан ололт амжилтын туршлага, эдийн засгийн өрсөлдөх чадвараараа дэлхийд тооцогдох Самсунг, Хёндэ гэх мэт корпорациудын брэнд болсон үнэ цэнэ, дэлхий дахинаа хурдацтай тархаж буй соёлыг түгээн дэлгэрүүлэх үзэгдэл буюу “Солонгосын давалгаа”, соёлын үйлдвэрлэл, контентуудаар дамжин илрэх өвөрмөц болон нийтлэг чанар хийгээд орчин үе ба уламжлалын тасралтгүй холбоо, ажилсаг хичээнгүй ард, аливаад сэтгэлээс ханддаг ард түмэн гэх мэт солонгос хүний дүр төрх, үнэлэмж зэргийг дурдсан байна(Geun, Lee, 2009b).

Шинэ олон нийтийн дипломат ажиллагаа нь дамжуулах мэдээллийн үүднээс мэдлэгийн дипломат ажиллагаа, дамжуулах суваг технологийн үүднээс дижитал дипломат ажиллагаа, сошиал дипломат ажиллагаа, зорилгын үүднээс сэтгэл татах дипломат ажиллагаа(attractive, charming), оролцогч тоглогчид болоод авч үзэж буй асуудлын төрөл зүйл өргөжин тэлж байгаа гэдэг утгаараа нетворк дипломат ажиллагаа, олон нийтэд хандсан гэдэг үүднээсээ нээлттэй дипломат ажиллагаа, сошиал дипломат ажиллагаа гэх мэтээр тодорхойлогдож байна.

## **2. Олон нийтийн дипломат бодлогын онолын үндэс буюу зөөлөн хүчний онолын тухайд.**

Даяаршил өргөжихийн хэрээр улс орнуудын харилцан хамаарал гүнзгийрэх болж, цэрэг зэвсэгт далайлган хүчээр тулгах болон эдийн засгийн хориг тавих зэргээс илүү хэлэлцэж зөвшилцөх, харилцан ойлголцох явдал олон улсын харилцаанд чухалчлагдах болсон нь олон улсын харилцааны онолын түвшинд зөөлөн хүчний талаарх ойлголтонд анхаарахад хүргэсэн нь дамжиггүй. Улс төр, олон улсын харилцаанд яригддаг хүчний тухай ойлголт, тухайлбал хатуу хүч болон зөөлөн хүчний ойлголт нь агуулгын хувьд шинэ зүйл биш юм. Олон улсын харилцаан дахь хүчний тухай ойлголтыг олон эрдэмтэн тодорхойлохыг оролдож

ирсэн. Олон улсын харилцааны сонгодог реалист үзэл баримтлалын эцэг гэгдэх Ханс Моргентау “Хатуу хүч гэдэг нь зорилгодоо хүрэх шууд арга зам бөгөөд улс төр, эдийн засаг, цэрэг зэвсгийн аргаар бусдын оюун санаа болоод тэдний үйлдлийг хянах чадвар юм” (Morgenthau, 1948; 2014) гэж тодорхойлоод олон улсын харилцаа бол уг хүч чадлын төлөөх тэмцэл юм гэжээ. Харин зөөлөн хүчний талаарх ойлголтыг олон улсын харилцааны онолын түвшинд оруулж ирсэн Жозеф Най(2004) хүчийг өөрийн эзэмшиж буй тодорхой нөөц дээр үндэслэн бусдын үйлдэлд нөлөө үзүүлэн, өөрийн хүсэж буй үр дүнг олж авах чадвар гэж үзжээ.

Зөөлөн хүч ч мөн хүч чадал, эрх мэдлийн төлөөх тэмцэл юм. Жозеф Най “зөөлөн хүч нь албадах юм уу, төлбөр төлөх замаар бус, ятгах юм уу, сэтгэлийг нь татах замаар тэдний хүссэнээр өөрийн хүссэнээ гүйцэлдүүлэх чадвар юм” гэж тодорхойлоод “...аливаа улс өөрийн орны оюун санаа болоод соёлын үнэт зүйлсийн тусламжтайгаар бусад улсуудын ашиг сонирхол, төлөв байдалд шууд бус замаар нөлөөлөх чадвар” гэж онцлон тодотгожээ(Нье, 2004). Өөрөөр хэлбэл аль нэгэн улсын үнэт зүйлийн систем(ардчилал, хүний эрх, хувь хүнд олгож буй боломж г.м)-ийг хүндэтгэн үзэж, тухайн улсыг үлгэр жишээ болгон даган дууриахад хүргэх үзэл санааны өөрчлөлтийг аль нэг улсын иргэдэд төрүүлж, улмаар улсын гадаад дотоод бодлогод нөлөөлөх хүч гэж ойлгож болно. Эдгээр тодорхойлолтуудаас харахад хатуу болон зөөлөн хүч нь нийтлэг болон ялгаатай талтай. Зорилго нь нийтлэг бол зорилгодоо хүрэх арга хэлбэр нь өөр юм. Өөрөөр хэлбэл аль аль нь бусдад нөлөөлөх замаар зорилгодоо хүрэхийг эрмэлздэг ч арга хэлбэр нь өөр юм. Нэг нь заналхийлэл, шан харамжаар бусдын хийх гэж буй үйлдлийг өөрчилдөг бол нөгөө нь бусдын юу хүсэхийг хэлж зааж өгөн оюун санааг нь татан дагуулдаг гэж ойлгож болно.

Най зөөлөн хүчний мөн чанарыг авч үзэхээс гадна хүч хатуу хүчнээс зөөлөн хүч рүү шилжих үйл явцыг онцлон авч үзсэн. Тэрээр олон улсын нийгэмлэгүүд өсөн нэмэгдэж, мэдээлэл технологийг дагасан нетворк тархалтаас шалтгаалан XXI зууны олон улсын харилцаан дахь хүч нь цэргийн хүч юм уу эдийн засгийн чадвар гэх мэт хүч түрэх, түлхэж шахах хатуу хүчнээс соёл, үзэл баримтлал, дипломат ажиллагаа зэрэгт суурилсан, ятгах, зөвшилцөх үйл явцаар дамжуулан ажилладаг зөөлөн хүчний механизм руу шилжиж байна гээд шилжих үйл явц нь 1) хүчээр албадах, 2) урхидах, ятгах 3) хэлэлцэх асуудлыг товлох, 4) сэтгэл татах гэсэн 4 шат дамжлагыг дамждаг гэжээ. Тэрхүү шилжих үйл явцын шат дамжлага бүрт тохирох нөөцийг ашиглах бөгөөд тэр нь 1) зэвсгийн хүч болон эдийн засгийн хориг, 2) нөхөн төлбөр төлөх болон худалдан авах, 3) систем тогтолцоо тогтоох, 4) үнэт зүйл ба соёлын бодлого гэж үзжээ(Нье, 2004). Түүний зөөлөн хүчний тухай ойлголт XXI зууны олон улсын харилцаан дахь хүчний харьцааны өөрчлөлтийн явцыг тодорхойлох оролдлого байсан гэж судлаачид үнэлдэг. Хүчний харьцааны өөрчлөлттэй холбоотойгоор орчин үеийн олон улсын харилцаан дахь уламжлалт бус дипломат харилцааны асуудлууд, тухайлбал соёл хүмүүнлэг, хүний эрх, хүрээлэн буй орчин гэх мэт шинэ хүчний(цэрэг, эдийн засгийн хүчнээс бусад гэж

ойлгож болно) асуудлуудыг зөөлөн хүчний ойлголтоор тайлбарлах болсон билээ. Зөөлөн хүчний онол нь олон улсын харилцааны хүчний тухай онолд харьцангуй үл тоомсорлогдож байсан соёл, үзэл баримтлал, итгэл үнэмшил гэх мэт материаллаг бус хувьсагчуудыг гаргаж ирэн, үүнийг хатуу хүчтэй холбон авч үзэх арга замыг зааж өгсөн төдийгүй олон улсын харилцааны тоглогчдын харилцаанаас хүч үүсэн гарч ирдэг гэдэгт салбарынхны анхаарлыг хандуулж чадсанаараа ач холбогдолтой юм (김상배, 2009).

Най зөөлөн хүчний нөөцөд соёл урлаг, үзэл баримтлал, үнэт зүйлийн тогтолцоо, гадаад бодлого-дипломат ажиллагаа зэрэг материаллаг бус нөөцүүдийг багтааж үзсэн байна. АНУ, Англи гэх мэт хүчирхэг гүрнүүд хатуу, зөөлөн хүчний нөөцөөр баялаг агаад аль алийг нь хослуулан хэрэглэж ирсэн. Тухайлбал, АНУ нь соёлын болон улс төрийн хүрээнд зөөлөн хүч чадлыг тун амжилттайгаар хэрэгжүүлснийг болоод одоо ч зогсолтгүй хэрэгжүүлж буйг дараах олон зүйлсээс нотолж болно. Юуны өмнө хүйтэн дайны дараах олон улсын тавцанд тэргүүлэх болсон ардчилалын үзэл баримтлал. Ардчилал, хүний эрх, эрх чөлөөг хүндлэн дээдэлсэн төр засаг, эдийн засаг, санхүүгийн бодлого, цагаачлалын нээлттэй бодлого зэрэг нь дэлхий нийтийн талархлыг хүлээж, америкаар овоглосон бүхнийг шүтэх болсон гэж хэлэхэд хилсдэхгүй. Америкийн олон нийтийн соёл(popular culture) болох холливудын кинонууд, рок поп дуу хөгжим, коко кола, мак دونالدсын дэлхийг бүрхсэн сүлжээ нь нэгэнтээ хэрэгжсэн зөөлөн хүчийг харуулах бол мэдээлэл холбоо, технологийн үсрэнгүй хөгжилд суурилсан Силивүүд(Silicon Valley+Hollywood)-ийн толгой эргэм амжилт өнөөдөр зөөлөн хүчний бодлого дэлхий дахинаа тасралтгүй хэрэгжсээр байгааг илтгэнэ. АНУ-ын соёл, үнэт зүйлс, гадаад бодлогыг дэлхийн бусад улсууд сайшаан хүндэтгэж байна гэдэг нь тус улс зөөлөн хүч чадлаар баян байна гэсэн үг юм.

Азийн бүс нутагт Япон, өмнөд Солонгос соёлын нөөцийг өргөн ашиглан бүс нутагт төдийгүй дэлхий дахинд зөөлөн хүчийг амжилттай хэрэгжүүлж байгааг Японы “Cool Japan”, өмнөд Солонгосын “Солонгосын давалгаа” бодлогууд харуулна. Өнгөрсөн зууны эцсээр өвөрмөц өв уламжлал, үндэсний урлаг хийгээд драма буюу телевизийн олон ангит цувралаар дамжин хэрэгжиж байсан Японы зөөлөн хүч шинэ зууны босгон дээр өнгө төрхөө өөрчилж J-POP дуу хөгжим, зурагт ном, анимэшн, загвар дизайн зэрэг техник технологийн хөгжилд суурилсан соёлын үйлдвэрлэлээс бүрдэх “Cool Japan” хэмээх орчин үеийн нийтийн соёлыг нөөцөө болгосон юм. Харин БНСУ-ын зөөлөн хүчний амжилтыг бүс нутгаас хэдийнээ хальсан “солонгосын давалгаа”, тодруулбал, солонгос телевизийн сериал, К-POP дуу хөгжим ази төдийгүй европт нийтийн хүртээл болж, олон нийтийг байлдан дагуулж байгаа явдал, Самсунг фирмийн сүүлийн үеийн загварын гар утаснууд дэлхийн зах зээлд өндөр борлуулалттай байгаагаас, дэлхийн хоолны соёлд хэдийн нэвтэрсэн кимчи зэргээс бэлхэнээ харж болно. Шинэ зууны олон улсын харилцаанд тодрон гарч ирсэн Хятадын тухайд, хятад хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор

дэлхийн 142 улсын 516 хотод 1076 салбар<sup>3</sup> байгуулан тогтмол үйл ажиллагаа явуулж буй “Күнзийн институт” өнөөдөр Хятадын зөөлөн хүчний асар том нөөц болж байна.

Зөөлөн хүчний онол нь олон нийтийн дипломат ажиллагааны онолын үндэс болж өгдөг. Дээр дурдсанчлан Най зөөлөн хүчний нөөцөд соёл, үзэл баримтлал, үнэт зүйлийн тогтолцоо зэргээс гадна гадаад бодлого-дипломат ажиллагааг багтааж, онцлон авч үзсэн. Шинэ зууны хүчний харьцааны өөрчлөлтийн бодит байдал хийгээд Найн зөөлөн хүчний онол нь олон ч талаараа их гүрний олон нийтийн дипломат ажиллагаанд онолын үндэслэлийг нь хангаж өгдөг гэдгийг АНУ, Их Британи, ОХУ, БНХАУ гэх мэт их гүрнүүдийн гадаад бодлогын өөрчлөлтөөс нотолж болно. Харин БНСУ, Австрали, Энэтхэг гэх мэт бүс нутгийн томоохон улсуудын хувьд дунд хүчний улсын бодлогод нийцсэн олон нийтийн дипломат бодлогыг явуулж байна.

### 3. БНСУ-ын олон нийтийн дипломат бодлогын онцлог

БНСУ нь 2010 оноос олон нийтийн дипломат бодлогод онцгой ач холбогдол өгөх болж, улс төр, эдийн засаг, олон нийтийн дипломат бодлогыг гадаад бодлогынхоо үндсэн тулгуур бодлого болгон баталж, олон нийтийн дипломат ажиллагааг хөгжүүлэхэд бүх талын хүчин чармайлт гарган ажиллаж байна. 2017 оны V сараас гараагаа эхэлсэн Мүн Жэ Ины Засгийн Газрын гадаад бодлогын үндсэн 4 зорилгод<sup>4</sup> ард иргэдийн дипломат ажиллагаа буюу олон нийтийн дипломат ажиллагаагаар дамжуулан улс орны эрх ашгийг дээшлүүлэх гэсэн заалт орсон нь олон нийтийн дипломат ажиллагаанд хэр их ач холбогдол өгч байгааг харуулж байна. БНСУ-ын гадаад бодлогын үндсэн тулгуур элемент болохын хувьд улс төрийн дипломат бодлогын хүрээнд, эдийн засгийн гадаад бодлогын хүрээнд ч олон нийтийн дипломат бодлогыг ямагт тусгасан байдаг.

БНСУ-ын Соёл, биеийн тамир, аялал жуулчлалын яамнаас эрхлэн соёл урлаг голлосон олон нийтийн дипломат ажиллагааг явуулж ирсэн бол 2016 оны VIII сард “Олон нийтийн дипломат ажиллагааны тухай хууль” батлагдан хүчин төгөлдөр болсноор Гадаад Хэргийн Яамнаас уг бодлогыг эрхлэн явуулах эрх зүйн орчин нээгдсэн юм. Шинээр батлагдсан хуулийн 2-р зүйлд “Олон нийтийн дипломат ажиллагаа гэдэг нь улс болон орон нутгийн өөртөө удирдах байгууллага, иргэдтэй нягт хамтран ажиллаж соёл, мэдлэг, бодлого зэргээр дамжуулан гадаадын иргэдийн БНСУ-ын талаарх ойлголтыг дээшлүүлж, итгэлцлийг нэмэгдүүлэх дипломат үйл ажиллагааг хэлнэ.” хэмээн томъёолсон нь өмнөд Солонгосын олон нийтийн

<sup>3</sup> Cit.20/03/2018. Retrieved from.

<http://www.yonhapnews.co.kr/bulletin/2017/10/07/0200000000AKR20171007036400083.HTML>

<sup>4</sup> БНСУ-ын гадаад бодлогын үндсэн 4 чиглэл.

1) Хойд Солонгосын цөмийн асуудлыг шийдвэрлэж, энхтайванч систем тогтоох

2) Ард иргэдийн дипломат ажиллагаа, олон нийтийн дипломат ажиллагаагаар дамжуулан улс орны эрх ашгийг нэмэгдүүлэх

3) Эргэн тойрны 4 улстай хамтын ажиллагаатай дипломат ажиллагаа явуулах

4) Зүүн хойд ази хариуцлагатай хамтын нийгэмлэг бүрдүүлэх

Cit.20/03/2018. Retrieved from. [http://mcms.mofa.go.kr/trade/arms/index.jsp?mofat=001&menu=m\\_30\\_80](http://mcms.mofa.go.kr/trade/arms/index.jsp?mofat=001&menu=m_30_80)

дипломат ажиллагааны онцлогийг бүрэн тусгасан болохыг харуулж байна.<sup>5</sup> Хуулийн дагуу боловсруулсан шинэ бодлого болох “БНСУ-ын олон нийтийн дипломат ажиллагааны үндсэн төлөвлөгөө 2017-2021” өнгөрсөн оны эцсээр батлагдан 2018 оноос хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөөд ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд Засгийн газар, холбогдох яам хэрэгжүүлэгч байгууллагууд төдийгүй орон нутгийн удирдах байгууллагуудын ажил үүргийг нэг бүрчлэн тусгасан байна.<sup>6</sup> Хуулийн 8-р зүйлд заасанчлан БНСУ-ын олон нийтийн дипломат ажиллагааны төв байгууллага нь Гадаад хэргийн яамны сайдын шууд удирдлага дор байгуулагдсан “Олон нийтийн дипломат ажиллагааны хороо” юм.<sup>7</sup>

Үүний зэрэгцээ 2017 оны IX сараас хэрэгжиж эхэлсэн “Олон улсын соёлын харилцааг дэмжих тухай хууль” нь олон нийтийн дипломат ажиллагааг хэрэгжүүлэх хууль эрх зүйн таатай орчин бүрдэхэд зохих ач холбогдолтой билээ. Уг хуульд соёл, аялал жуулчлалын олон улсын үйл ажиллагаагаар дамжуулан олон нийтийн дипломат ажиллагаанд хувь нэмэр оруулах тухай гэх мэтчилэн Соёл, биеийн тамир, аялал жуулчлалын яамны олон нийтийн дипломат ажиллагаатай холбогдох үүрэг ролийг онцлон зааж өгсөн байна.<sup>8</sup>

Эдгээр бодлого, стратегийг боловсруулан боловсруулах төв байгууллага нь Гадаад Хэргийн Яамны сайд болон сайдын түвшний 20 гишүүн бүхий БНСУ-ын олон нийтийн дипломат ажиллагааны хороо, хэрэгжүүлэгч үндсэн байгууллага нь Гадаад Хэргийн Яам хийгээд гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд(178) болон Соёл, Аялал Жуулчлал, Спортын Яам болно. Мөн Олон Улсын Харилцааны Сан буюу Солонгосын Сан(Korea Foundation) нь Гадаад Хэргийн Яамны шууд удирдлага дор олон нийтийн дипломат ажиллагааг хариуцан явуулна.

БНСУ-ын Засгийн Газраас олон нийтийн дипломат ажиллагаанд зориулж батлан зарцуулсан төсөв хөрөнгийн хэмжээнээс харахад олон нийтийн дипломат ажиллагаанд анхаарал хандуулж, ач холбогдол өгч байгааг харж болно.

Хүснэгт 2. БНСУ-ын Засгийн газраас олон нийтийн дипломат ажиллагаанд зориулж баталсан төсөв (солонгос вон)

Он	2013	2014	2015	2016	2017
Баталсан төсөв (вон)	6 тэрбум	9 тэрбум	13 тэрбум	14,1 тэрбум	16 тэрбум

Эх сурвалж: БНСУ-ын Гадаад Хэргийн Яам. Олон нийтийн дипломат ажиллагаа цахим хуудас<sup>9</sup>

БНСУ-ын Засгийн Газар хууль эрх зүйн орчин ийн бүрдсэн таатай нөхцөлд олон нийтийн дипломат ажиллагааны бодлого, стратеги, ойр хэтийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулаад, энэ оноос хэрэгжүүлэхээр ажиллаж байна. БНСУ-ын

<sup>5</sup> Cit.20/03/2018. Retrieved from. <http://www.law.go.kr/lsEflInfoP.do?lsiSeq=180836#>

<sup>6</sup> Cit.20/03/2018. Retrieved from. <http://www.publicdiplomacy.go.kr/introduce/public.jsp>

<sup>7</sup> Cit.20/03/2018. Retrieved from. <http://www.law.go.kr/lsEflInfoP.do?lsiSeq=180836#>

<sup>8</sup> Cit.20/03/2018. Retrieved from. <http://www.law.go.kr/lsEflInfoP.do?lsiSeq=192467&efYd=20170922#0000>

<sup>9</sup> Cit.20/03/2018. Retrieved from. [http://www.publicdiplomacy.go.kr/summary/summary\\_main.jsp](http://www.publicdiplomacy.go.kr/summary/summary_main.jsp)

гадаад бодлогын баримт бичгүүд хийгээд холбогдох хууль тогтоомж, хуулийн хүрээнд боловсруулсан үндсэн бодлого, стратеги төлөвлөгөөнд тусгасан зүйл заалтуудад үндэслэн БНСУ-ын олон нийтийн дипломат ажиллагааны онцлогийг дараах байдлаар тодорхойлохыг оролдов.

1. БНСУ-ын улс төрийн дипломат бодлогын хүрээнд ч, эдийн засгийн гадаад бодлогын хүрээнд ч олон нийтийн дипломат бодлогыг тусгасан байдаг. Жишээ нь:

#### **Улс төрийн дипломат бодлогын хүрээнд:**

БНСУ-ын улс төрийн дипломат бодлогын тулгамдсан асуудал болох Солонгосын хойгийн тогтворгүй байдлыг зохицуулахад чиглэсэн гадаад бодлогод олон нийтийн дипломат ажиллагааг ашиглах талаар.

- 1) БНСУ-ын улсын умард Солонгосын талаарх бодлого, Солонгосын хойгийн нэгдэл гэх мэт өмнөд Солонгосын ирээдүйн хэтийн төлөвийн талаар өөрийн орны иргэдэд төдийгүй гадаад орны иргэдэд таниулан Солонгосын хойгийн нөхцөл байдлын талаарх айдас түгшүүрийг багасгах
- 2) Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагаагаар дамжуулан бүс нутгийн асуудлыг шийдвэрлэх бодлого, арга замыг боловсруулан нийтэд таниулах
- 3) Гадаад дотоодын иргэд, оюутан сурагчдад Солонгосын хойгийн ирээдүйн талаар эерэг сэтгэгдэл төрүүлэх үйл ажиллагааг идэвхтэй явуулах
- 4) Өмнөд, умард Солонгосын ард иргэдэд хуваагдсан нэгэн үндэстний нэгдэл, энхтайван, тогтвортой байдлыг хүсэмжлэх сэтгэгдэл төрүүлэх мессэжийг солонгос үндэстний түүх, соёлоос гаргаж ирэх, түүнийг улс төрийн харилцаанд ашиглах гэх мэтчилэн тусгасан байдаг.

#### **Эдийн засгийн гадаад бодлогын хүрээнд:**

- 1) Улс орны эдийн засгийн нөөц бололцоо, өндөр бэлтгэгдсэн боловсон хүчин, мэдээлэл технологийн хөгжил зэргийг боловсрол, эрдэм шинжилгээ, судалгаа, соёл урлаг, хүний хөгжил гэх мэт бусад салбаруудтай холбон эргээд боловсрол, соёл урлагийн салбараас эдийн засагт өгөөж өгөх, цаашлаад энэ бүхэн улс орны олон улсын нэр хүнд болоод солонгос хүний гадаад дахь үнэлэмжинд нөлөөлөх бодлогуудыг дэмжин ажиллахад чиглэж байна.
- 2) Солонгосын эдийн засгийн хөгжлийн түүх, амжилтын туршлагыг бусад улс орнуудтай хуваалцах, загвар улс болоход чиглэсэн эдийн засгийн судалгаа, хамтын ажиллагааг идэвхтэй явуулах, эдийн засгийн салбарт өндөр амжилт гаргасан томоохон корпораци, хүрсэн хувь хүний амжилтын түүхийг танилцуулах замаар өөрийн улс орны талаарх гадаадынхны сонирхлыг өсгөн нэмэгдүүлэх
- 3) Соёлын үйлдвэрлэл, соёлыг сурталчлан таниулан, түгээн дэлгэрүүлэх бодлогыг дэмжих замаар Солонгосын улсын нэр хүнд, брэнд, томоохон



үйлдвэрлэгчид, бараа бүтээгдэхүүний имиж, нэр хүндийг өсгөх, цаашлаад бараа бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлтийг нэмэгдүүлэх гэх мэтээр олон нийтийн дипломат ажиллагааны давуу талыг ашиглах бодлогуудыг тусгаж байна.

2. БНСУ-ын олон нийтийн дипломат бодлогын нэг онцлог нь бүс нутгийн улс орнуудтай, тухайлбал, Япон, БНХАУ-тай хамтарсан хоёр талт олон нийтийн дипломат ажиллагааг идэвхтэй явуулах тал дээр онцгойлон анхаарахын зэрэгцээ Япон, БНХАУ, БНСУ-ын хамтарсан гурван талт олон нийтийн дипломат ажиллагаа явуулах хамтын ажиллагааны механизмыг боловсруулж, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр зорьж байна. Үүний нэг жишээ нь БНСУ-ын олон нийтийн дипломат ажиллагааны үндсэн арга хэмжээнүүдийн нэг болох “Олон нийтийн дипломат ажиллагааны форум” юм. Энэхүү чуулга уулзалтыг улс орнуудтай тогтмол зохион байгуулж явуулахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд тухайлбал БНХАУ-тай 2015 оноос хойш 3 дахь удаагаа амжилттай зохион байгуулаад байна.
3. Олон нийтийн дипломат ажиллагааны нетворкыг өргөжүүлэх, дэд бүтцийг сайжруулахад анхааран ажиллаж байна. Ард иргэд, сургууль, эрдэм шинжилгээ, боловсролын байгууллага, хэвлэл мэдээллийн салбар, төрийн бус байгууллага, компани, корпорациуд, гадаадад амьдардаг солонгос гаралтай иргэдийн нийгэмлэг гэх мэт байгууллага иргэдийн хоорондын болоод гадаадын ижил төстэй байгууллагуудтай тогтоосон холбоо харилцааг дэмжих, шинээр харилцаа тогтоох зэргээр олон нийтийн дипломат ажиллагааны нетворк сүлжээг өргөжүүлэн тэлэх, үйл ажиллагааг нь өргөн хүрээнд явуулахад чиглэн ажиллаж байна. Зөвхөн хилийн чанадад төдийгүй БНСУ-д ажиллаж амьдарч байгаа гадаад иргэдийг татан оролцуулах, тухайн улсын Элчин Сайдын Яамтай хамтран тэдэнд зориулсан арга хэмжээ зохион байгуулах, төрөл бүрийн дэмжлэг туслалцаа үзүүлэх гэх мэт олон ажил санаачлагуудыг дурдаж болно. Ийнхүү нетворк сүлжээг өргөжүүлснээр олон нийтийн дипломат ажиллагааны стратеги, хэрэгжүүлэх арга замын талаар санал бодол солилцохоос эхлүүлээд Засгийн Газраас явуулж буй олон нийтийн дипломат бодлогын талаарх иргэдийн хандлага, үр дүн зэргийг судалж мэдэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.
4. Олон нийтийн дипломат ажиллагаан дахь ард иргэдийн оролцоог дэмжих бодлого. Олон нийтийн дипломат ажиллагааг нь гадаадын төдийгүй дотоодын иргэдэд хандуулж, тэдэнд та өөрөө ч олон нийтийн дипломат ажиллагааны тоглогч гэсэн ойлголтыг суулгаж, тэдний оролцоог нэмэгдүүлэх, идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд нь дэмжихэд чиглэсэн “Иргэн бүр дипломатч” гэх зэрэг төсөл хөтөлбөрүүдийг хилийн чанад дахь Дипломат Төлөөлөгчийн Газруудтай хамтран явуулдаг. Ийнхүү иргэдийг идэвхжүүлснээр иргэд өөрсдөө гардан оролцох, нийгмийн идэвхээ дээшлүүлэхээс гадна төсөв хөрөнгө дутагдалтай үед иргэд хандив дэмжлэг үзүүлэх зэргээр хувь

нэмрээ оруулдаг. Улс орнуудын харилцаанд иргэд, иргэдийн нийгэмлэгийн оролцоо өсөн нэмэгдэхийн хэрээр гадаад улсын иргэдтэй Засгийн Газрын зүгээс харилцахаас илүү иргэд, иргэдийн нийгэмлэг харилцах нь үр дүнтэй юм. Үүнд БНСУ-ын олон нийтийн дипломат бодлогын үндсэн хэсэг болох иргэн бүр дипломат гэсэн бодлогын ач холбогдол оршиж байгаа юм.<sup>10</sup>

#### 4. БНСУ-ын олон нийтийн дипломат үйл ажиллагаа

БНСУ-ын гадаад бодлогынхоо үндсэн тулгуур бодлогын хүрээнд олон нийтийн дипломат бодлогыг авч үзэх болсон. Дипломат ажиллагаан дахь ард иргэдийн оролцоог чухалчлан үзэж, олон нийтийн дипломат бодлогынхоо эрхэм зорилгыг “Ард түмэнтэйгээ хамтдаа дэлхий дахинтай ойлголцох сэтгэл татам БНСУ” хэмээн тодорхойлж, дараах үндсэн зорилтуудыг тавьж байна. Үүнд:

- 1) Соёлын баялаг нөөцийг ашиглан олон улсын үнэлэмжээ дээшлүүлэх, улсын имиж нэр хүндийг өсгөх,
- 2) БНСУ-ын талаар зөв ойлголт өгөх,
- 3) БНСУ-ын явуулж буй бодлогын талаарх найрсаг таатай орчинг бүрдүүлэх,
- 4) Олон нийтийн дипломат ажиллагаанд оролцогсдын хүрээг өргөжүүлж, харилцан хамтын ажиллагаатай тогтолцоог бэхжүүлэх гэсэн үндсэн 4 зорилго бүхий олон нийтийн дипломат бодлогыг хэрэгжүүлж байна. Энэхүү зорилтынхоо хүрээнд дараахь байдлаар олон нийтийн дипломат бодлогынхоо стратеги чиглэлүүдийг боловсруулан тавьжээ.
  - 1) Соёл- олон нийтийн дипломат ажиллагаа. Соёлын дэвшилтэт улсын хувьд соёлын баялаг нөөцөө ашиглан “сэтгэл татам байдлаа” түгээн дэлгэрүүлэх, харилцан чиглэсэн соёлын харилцаагаар дамжуулан улс хоорондын харилцан ойлголцлыг дээшлүүлэхэд чиглэнэ.
  - 2) Мэдлэг-олон нийтийн дипломат ажиллагаа. Солонгосын түүх, өв уламжлал, хөгжлийн туршлага зэргийн талаарх ойлголтыг дэлгэрүүлэх, солонгос хэл судлалыг дэмжих, түгээн дэлгэрүүлэхэд гол анхаарлаа хандуулна.
  - 3) Бодлого голлосон- олон нийтийн дипломат ажиллагаа. Өөрийн явуулж буй бодлогын талаар үнэн зөв ойлголт өгөх, БНСУ дахь гадаад иргэдэд зориулсан бодлогыг сайжруулах зэрэгт чиглэнэ.
  - 4) Ард иргэдтэйгээ хамтдаа явуулах олон нийтийн дипломат ажиллагаа. Ард иргэдийн оролцоо, хамтын ажиллагаагаар дамжуулан олон нийтийн дипломат ажиллагааг идэвхжүүлэн бэхжүүлэх явдлыг чухалчлан үзнэ.
  - 5) Олон нийтийн дипломат ажиллагааны дэд бүтцийг сайжруулах тухай стратеги бодлого нь Засгийн Газар, орон нутгийн биедаасан удирдах байгууллага, иргэдийн хоорондын хамтын ажиллагаа, түүнийг зохицуулах

<sup>10</sup> “БНСУ-ын гадаад бодлогын үндсэн зорилт ба үүрэг”

[http://mcms.mofa.go.kr/trade/arms/index.jsp?mofat=001&menu=m\\_30\\_80](http://mcms.mofa.go.kr/trade/arms/index.jsp?mofat=001&menu=m_30_80)

[http://mcms.mofa.go.kr/trade/purpose/keynote/index.jsp?menu=m\\_30\\_10\\_10](http://mcms.mofa.go.kr/trade/purpose/keynote/index.jsp?menu=m_30_10_10)

“БНСУ-ын олон нийтийн дипломат ажиллагааны үндсэн төлөвлөгөө 2017-2021”

[http://www.publicdiplomacy.go.kr/summary/summary\\_personal01.jsp](http://www.publicdiplomacy.go.kr/summary/summary_personal01.jsp)

үндсэн системийг тогтоох, олон нийтийн дипломат ажиллагааны олон улсын нетворкыг бэхжүүлэх, олон нийтийн дипломат ажиллагааны ололт амжилтыг дүгнэх системийг бий болгох, мэдээлэл хуваалцах болон харилцан нэвтрэлцэх цахим систем байгуулах, олон нийтийн дипломат бодлого боловсруулахад зориулсан суурь судалгаа явуулах зэрэг улсын үүрэг ролийг онцлон тусгасан байна.<sup>11</sup>

БНСУ-ын олон нийтийн дипломат бодлого, стратегийн хүрээнд хэрэгжүүлэгч байгууллагуудаас явуулж буй үндсэн үйл ажиллагаанаас дурдвал:

Засгийн Газар хоорондын олон нийтийн дипломат ажиллагааны хүрээнд,

- 1) Олон нийтийн дипломат ажиллагааны форум. Гадаад орнуудын Засгийн Газар, иргэд, эрдэм шинжилгээ, хэвлэл мэдээллийн салбарын мэргэжилтнүүд оролцож, өөрийн орны олон нийтийн дипломат ажиллагааны бодлого, стратеги, үйл ажиллагааны туршлагаасаа хуваалцах, хамтарсан арга хэмжээ хөтөлбөрүүдийг төлөвлөх зэргээр иргэд хоорондын харилцан ойлголцол, ойлголтуудыг дээшлүүлэх зорилго бүхий хоёр олон талт форум юм. Одоогийн байдлаар БНХАУ-тай хамтран зохион байгуулаад байгаа бөгөөд цаашид бусад улс орнуудтай зохион байгуулахаар төлөвлөж байна.<sup>12</sup>
- 2) Засгийн газар хоорондын Соёлын хэлэлцээр. БНСУ-ын Засгийн Газар нь дипломат харилцаатай улс орнуудтай соёлын хэлэлцээр байгуулж, хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш Соёлын солилцооны хөтөлбөр(Cultural Exchange Programme)-ийг боловсруулан баталж, 2-3 жилийн давтамжтайгаар хоёр орны цаашдын соёлын харилцаа, хамтын ажиллагааны чиг хандлага, арга замыг тогтоож, түүнийхээ дагуу соёлын харилцааг явуулж ирсэн. Хоёр орны соёлын хэлэлцээр нь боловсрол, эрдэм шинжилгээний салбарын хамтын ажиллагаа, соёл, урлагийн салбарын харилцаа, биеийн тамир, хүүхэд залуучуудын харилцаа, хэвлэл мэдээллийн салбарын хамтын ажиллагаа, шинжлэх ухаан технологийн салбарын хамтын ажиллагаа зэргийг багтаасан байдаг. Одоогийн байдлаар 103 улс соёлын хэлэлцээрт гарын үсэг зурж байгуулснаас 98 улстай хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Монгол улстай 1991 онд байгуулсан.
- 3) Соёлын хамтарсан хороо. Соёлын хэлэлцээр болон Засгийн Газар хоорондын бусад баримт бичгийн дагуу хоёр талын Соёлын яамны сайдын түвшний албан тушаалтнаар ахлуулсан ЗГ хоорондын соёлын хамтарсан хороог байгуулж ажилладаг. 2-3 жил тутам хоёр тал ээлжээр соёлын хамтарсан хорооны хурлыг зохион байгуулж, соёлын солилцооны хөтөлбөрийг хэлэлцэн баталдаг. Монгол Улстай анх 2011 оны XI сард Соёлын хамтарсан

<sup>11</sup> “БНСУ-ын олон нийтийн дипломат ажиллагааны үндсэн стратеги төлөвлөгөө 2017-2021”, Cit.20/03/2018. Retrieved from. [http://www.publicdiplomacy.go.kr/summary/summary\\_main.jsp](http://www.publicdiplomacy.go.kr/summary/summary_main.jsp)

<sup>12</sup> Хоёр улсын ГХЯ-наас хамтран зохион байгуулсан, БНСУ-ын Олон Улсын Солилцооны сан(Солонгосын Сан) болон БНХАУ-ын ОНДА-ны нийгэмлэг гол оролцогчоор оролцсон “3 дахь удаагийн БНСУ-БНХАУ-ын олон нийтийн дипломат ажиллагааны форум” 2015.11.19-нд Сөүлд болов. 2000 орчим хүн оролцсон уг форумар хоёр улс олон нийтийн дипломат ажиллагааны бодлого, соёлын харилцаа, хэвлэл мэдээллийн хамтын ажиллагаа ба олон нийтийн дипломат ажиллагаа гэсэн асуудлаар хэлэлцэж, санал бодлоо хуваалцсан байна.

- хороо байгуулсан ба III хурлыг зохион байгуулаад байна.
- 4) ЮНЕСКО-той явуулах хамтын ажиллагаа. БНСУ-ын анх 1950 онд ЮНЕСКО-д элсэнээс хойш тус байгууллагын үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж, ЮНЕСКО-н нэгдсэн болон салбар хуралдаануудад тасралтгүй оролцож, санал бодлоо илэрхийлж ирсний сацуу өөрийн соёлын өвийг дэлхийн соёлын өвд бүртгүүлэх, өөрийн соёлыг хилийн чанадад таниулан сурталчлахад хичээн зүтгэж байна.<sup>13</sup>
  - 5) Гадаад харилцааны тэмдэглэлт ойн үйл ажиллагаа. БНСУ-тай дипломат харилцаа тогтоосны 10, 25 жилийн тэмдэглэлт ой гэх мэт хоёр талын харилцаанд онцгой ач холбогдол бүхий тэмдэглэлт ой тохиосон жилийг “харилцааны жил”, “найрамдлын жил” хэмээн зарлан тухайн улсуудтай улс төр, эдийн засаг, соёл гэх мэт бүхий талын салбаруудыг хамарсан нэгдсэн арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж ирсэн. Үүний зэрэгцээ хоёр талын үндэсний баяр, тэмдэглэлт ойг тохиолдуулсан баярын арга хэмжээг зохион байгуулж, Солонгосын уламжлалт соёл, хоол, хувцас, спорт, дэлгэцийн урлаг гэх мэт соёлын баялаг нөөцөөсөө гадаад орны ард иргэдэд танилцуулдаг нь улсын имиж, нэр хүндийг өсгөх төдийгүй түүгээр дамжуулан иргэд хоорондын харилцан ойлголцолд хувь нэмэр оруулдаг.
  - 6) Харилцан чиглэсэн соёлын харилцааг хөгжүүлэх арга хэмжээ. БНСУ-ын Гадаад Хэргийн Яам нь дэлхийн улс орнуудтай соёлын хамтын ажиллагааны сүлжээг бэхжүүлж, Солонгосын соёлын давалгааны нэг талт чанарыг нөхөхийн зэрэгцээ өөрийн ард иргэдийн соёлын олон талт чанарын талаарх ойлголтыг өргөжүүлэхийн тулд өмнөд Солонгост сайтар танигдаагүй улс орон, бүс нутгийн соёлыг танилцуулах “Харилцан чиглэсэн соёлын харилцааг хөгжүүлэх хөтөлбөр” (Mutual Cultural Exchange Program)-ийг хэрэгжүүлж ирсэн.<sup>14</sup>

Гадаадын иргэдэд чиглэсэн олон нийтийн дипломат ажиллагаа нь чухал байр суурийг эзэлнэ. Гадаадын иргэдэд чиглэсэн олон нийтийн дипломат ажиллагаа нь хилийн чанад дахь Дипломат Төлөөлөгчийн Газруудаас ард иргэдийн шууд оролцоотойгоор явагддаг байна.

- 1) “Солонгосын давалгаа”-г түгээн дэлгэрүүлэх олон нийтийн дипломат ажиллагаа. Гадаад улс орнуудад Солонгосын соёлын урсгал буюу “Солонгосын давалгаа”-г түгээн дэлгэрүүлэхийг дэмжих замаар БНСУ-ын талаарх сонирхлыг гүнзгийрүүлж, Солонгос улс болон Солонгосын ард иргэд, бараа бүтээгдэхүүний имиж, брэндийн нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн арга ажиллагаа.
- 2) “Иргэн бүр дипломатч” олон нийтийн дипломат ажиллагаа. Эх орноо

<sup>13</sup> 2016-2017 оны байдлаар ЮНЕСКО-н төсвийн 2.039%-ийг бүрдүүлэх(13р байр) 7,5 тэрбум воньг(64 сая ам доллар) төсөвлөн зарцуулсан. Дэлхийн өвийн сангийн төсвийн 1%, Төв Азийн эрдэм шинжилгээ судалгааны төвийн төсвийн 1%, Биет бус өвийг хамгаалах конвенцийн төсвийн 1% зэргийг тус тус хариуцан гаргасан. ЮНЕСКО-с хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдээс 28 төсөл хөтөлбөрт 36 сая ам долларын санхүүжилт олгоод байна.

<sup>14</sup> Cit.20/03/2018. Retrieved from. [http://www.publicdiplomacy.go.kr/summary/summary\\_main.jsp](http://www.publicdiplomacy.go.kr/summary/summary_main.jsp)

- сурталчлах шилдэг хөтөлбөрийг шалгаруулж хэрэгжүүлэх замаар ард иргэд олон нийтийн дипломат ажиллагааны төсөл хөтөлбөрүүдийн төлөвлөлт, хэрэгжилтийн түвшинд шууд оролцох боломж олгох хөтөлбөр.
- 3) Солонгосын долоо хоног арга хэмжээ. Семинар, форум, үзэсгэлэн, тоглолт гэх мэт олон төрлийн аргаар тухайн суугаа орондоо зохицсон байдлаар өмнөд Солонгосын сэтгэл татам талуудаг танилцуулах арга хэмжээ.
  - 4) Солонгос хэл, солонгос судлалыг дэмжих хөтөлбөрүүд. Солонгос хэл, солонгос судлалыг дэмжих олон талт хөтөлбөрүүдийг зохион байгуулахаас гадна суугаа орны голлох их сургууль, номын сан, соёлын төвүүдэд Солонгосын мэдээлэл технологийн тэргүүлэн технологи дээр суурилсан Солонгосыг сурталчлах Korea Corner байгуулах ажил зэрэг багтана.
  - 5) Соёл, спортын дипломат ажиллагаа, тэквондог дэмжих хөтөлбөрүүд. Гадаадын нэр хүндтэй иргэдийг Солонгосыг сурталчлах элчээр ажиллуулах, суугаа орны иргэдээс бүрдсэн солонгосын соёлын дугуйлан, теквандогийн дугуйлан, Солонгост суралцаж, ажиллаж байсан иргэд сайн дураараа Солонгос орныг сурталчлах K-Lover (дотоо гадаад иргэн) арга хэмжээ зэргийг дурдаж болно.
  - 6) Ардын дипломатчдын бүлэг. Гадаад дотоодод амьдарч буй залуучуудын сайн дурын, шинэ санаа, санаачлагад тулгуурлан ажилладаг “Залуу дипломатчдын бүлэг”, Ахмадуудын баялаг туршлага, мэдлэг оюунд тулгуурлан ажилладаг “Ахмад дипломатчдын бүлэг”-ийнхний бүтээлч санаачлагыг дэмжин ажилладаг.
  - 7) K-pop World Festival, Quiz on Korea Global Contents Contest гэх мэт олон улсын чанартай уралдаан тэмцээнүүд. Quiz on Korea, K-food World Festival, K-pop World Festival, видео бичлэгийн уралдаан гэх мэт гадаад хүмүүсийн өмнөд Солонгосын талаарх мэдлэг, чадварыг сорих уралдаан тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулж байна.
  - 8) “Дэлхийн соёлын мод” хөтөлбөр. Урлаг соёлын залуу боловсон хүчин, уран бүтээлчдийг хөгжиж буй орнуудад соёлыг түгээн дэлгэрүүлэх баг болгон илгээж, соёл сурталчлан таниулах нэгэн төрлийн соёлын солилцооны хөтөлбөр юм.
  - 9) Боловсролын салбарын хамтын ажиллагаа. БНСУ-д суралцагчдыг дэмжих тэтгэлэгийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэхээс авхуулаад гадаад орнуудын бага дунд сургуулийн сурах бичиг өмнөд Солонгосын хөгжлийн түүхийн талаар бичиж оруулах ажил, суугаа орны орон нутгийн хотуудаар аялж Солонгосыг таниулан сурталчлах гэх мэт олон ажлуудыг дурдаж болно.
  - 10) Хүүхэд залуучуудын харилцааг хөгжүүлэх хөтөлбөр. Өөрийн улсын оюутнуудыг хилийн чанад дахь Дипломат Төлөөлөгчийн Газрууддаа илгээж, суугаа оронд явуулж буй олон нийтийн дипломат ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээнд гар бие оролцох боломжоор хангах хөтөлбөр зэргийг дурдаж болно.<sup>15</sup>

<sup>15</sup> Cit.20/03/2018. Retrieved from. [http://www.publicdiplomacy.go.kr/summary/summary\\_main.jsp](http://www.publicdiplomacy.go.kr/summary/summary_main.jsp)

## ДҮГНЭЛТ

XXI зууны олон улсын харилцаанд гарсан хүчний харьцааны өөрчлөлт нь соёл, үзэл баримтлал оюун санааны үнэт зүйлс гэх мэт материаллаг бус нөөцийг үндсэн элементээ болгосон зөөлөн хүчний ач холбогдлыг өсгөх болсон билээ. Зөөлөн хүчний онол нь олон нийтийн дипломат ажиллагааны онолын үндэс болдог. БНСУ зөөлөн хүчний бодлогыг гадаад бодлогынхоо тулгуур бодлогын нэг, үндсэн стратеги болгон чухалчлан авч үзэх болсон. 2016 онд баталсан БНСУ-ын “Олон нийтийн дипломат ажиллагааны тухай хууль” болоод төсөвт суулгасан мөнгөн хөрөнгийн хэмжээ зэргээс тус улс олон нийтийн дипломат бодлогод өндөр ач холбогдол өгдөг болохыг харж болно. Бүс нутгийн энхтайвны асуудал, умар өмнөдийн нэгдлийн бодлого, БНСУ-ын олон улсын нэр хүндийг олон улсын тавцанд өргөх гэх мэт улс төрийн дипломат бодлогын хүрээнд ч, соёлын үйлдвэрлэл, солонгосын брэнд имиж зэргээр эдийн засгийн гадаад бодлогын хүрээнд ч олон нийтийн дипломат ажиллагааг амжилттай ашиглаж байна. БНСУ-ын олон нийтийн дипломат бодлогын нэг онцлог нь бүс нутгийн улс орнуудтай, тухайлбал, Япон, БНХАУ-тай хамтарсан хоёр талт олон нийтийн дипломат ажиллагааг идэвхтэй явуулах тал дээр онцгойлон анхаарахын зэрэгцээ Япон, БНХАУ, БНСУ-ын хамтарсан гурван талт олон нийтийн дипломат ажиллагаа явуулах хамтын ажиллагааны механизмыг боловсруулж, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр зорьж байна. БНСУ-ын олон нийтийн дипломат бодлого нь олон нийтийн дипломат ажиллагааны тухай хуулийн хүрээнд, удирдлагын төв агентлаг, хэрэгжүүлэгч байгууллага, олон тооны оролцогч бүхий бүхэл бүтэн системийн хүрээнд явагддаг. Олон нийтийн дипломат ажиллагааны гурван талт хамтын ажиллагааны механизм, олон нийтийн дипломат ажиллагааны нетворк бүтэц, харилцаа сүлжээг сайжруулахад чиглэсэн оролдлогууд, улс бус тоглогч буюу гадаад дотоодын ард иргэд, иргэдийн нийгэмлэг, бизнесийн байгууллагууд гэх мэт иргэдийн оролцоог дэмжиж, олон нийтийн дипломат ажиллагаагаар дамжуулан холбоо харилцааг нь бэхжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг дурдаж болно.

### НОМ ЗҮЙ

1. Geun Lee, 2009a, “A Theory of Soft Power and Korea’s Soft Power Strategy”, The Korean Journal of Defence Analysis, 21(2), pp.205-218.
2. Morgenthau, Hans, 1948, Politics among Nations: The Struggle for Power and Peace, New York: Alfred A.Knopf.
3. 한스 모겐소, 『국가 간의 정치: 세계평화의 권력이론적 접근 Ⅰ,Ⅱ』, 이호재, 엄태암 옮김, 2014, 김영사.
4. 2009b, “A Soft Power Approach to the Korean Wave”, The Review of Korean Studies, 12(2), pp.123-137.
5. Nye, Joseph S, 2004. Soft Power: The Means to Success in World Politics. New-York: Public Affairs.
6. 조세프 S. 나이, 『소프트 파워』, 홍수원 옮김, 2004, 세종연구원.
7. 2008. The Powers to Lead, Oxford and New-York: Oxford University Press.
8. 조지프S. 나이 지음, 『리더십 에센셜』, 김원석 옮김, 2008, 교보문고.
9. 2008. “Public Diplomacy and Soft Power”, The ANNALS of the American Academy of Political and Social Science, 616(1), pp.94-109.
10. Simona Vasilevskyte, 2013, “Discussing Soft Power Theory after Nye: The Case of Geun Lee’s Theoretical Approach”, Regionines Studijos, No7, pp.145-157.
11. 김상배, 2014, 『아라크네의 국제정치학: 네트워크 세계정치이론의 도전』, 한울.
12. 김상배 엮음, 2009, 『소프트 파워와 21세기 권력: 네트워크 권력론의 모색』, 한울.
13. 김상배, 이승주, 배영자 엮음, 2013, 『중견국의 공공외교』, 사회평론.
14. 신진, 2017, “공공외교의 한-미간 비교연구”, 『대한 정치학회보』, 25(4), 1-26쪽.
15. 이근, 2010, “국내외 공공외교 현황 파악 및 한국 대민외교 전략: 문화, 지식 외교”.
16. 조기제, 2016, “소프트 파워 강국으로서의 한국: 가능성과 과제”, 『평화학논총』, 6(1), 85-104쪽
17. 대한민국 외교부, 2016, 『제1차 대한민국 공공외교 기본 계획 (2017-2021)』
18. 대한민국 외교부, 2018, 『2018년도 공공외교 종합시행 계획』
19. 대한민국 외교부, 『2014년 재외공관 공공외교 활동성과』
20. 대한민국 외교부, 『2015년 재외공관 공공외교 활동성과』
21. 대한민국 외교부, 『2016년 재외공관 공공외교 활동성과』
22. 대한민국 외교부 공식 웹사이트, 외교정책 부문.
23. [http://mcms.mofa.go.kr/trade/arms/index.jsp?mofat=001&menu=m\\_30\\_80](http://mcms.mofa.go.kr/trade/arms/index.jsp?mofat=001&menu=m_30_80)
24. [http://mcms.mofa.go.kr/trade/purpose/keynote/index.jsp?menu=m\\_30\\_10\\_10](http://mcms.mofa.go.kr/trade/purpose/keynote/index.jsp?menu=m_30_10_10)
25. 대한민국 외교부 공식 웹사이트, 공공외교 부문. [http://www.publicdiplomacy.go.kr/summary/summary\\_personal01.jsp](http://www.publicdiplomacy.go.kr/summary/summary_personal01.jsp)

